

МОНГОЛ УЛСЫН ГАДААД
ХАРИЛЦААНЫ ГОЛ ҮЙЛ ЯВДЛУУД
(1995 оны II хагас)

1995.05.18. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат Франц Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсонтой нь холбогдуулан М.Ширакт баяр хүргэж цахилгаан утас илгээв.

1995.05.22. Нийслэлийн Засаг дарга Ц.Баасанжав тэргүүтэй төлөөлөгчид Сөүл хотын дарга Бьюнг-юл Чойн урилгаар тус хотод айлчлав.

1995.05.26. Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн П. Очирбатад ОХУ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын орлогч В.А.Рубанов тэргүүтэй төлөөлөгчид бараалхав.

1995.05.27. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатад Бүгд Найрамдах Гана улсаас манай улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Жон Евунтомах Бавах итгэмжлэх жуух бичгээ барив.

1995.05.29. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатад Швейцарын Холбооны Улсаас манай улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ули Зигг итгэмжлэх жуух бичгээ барилаа.

1995.05.28-30. Азийн залуучуудын Зөвлөлийн Сөүл хотноо болсон VI чуулганд Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд Э.Гомбожав нарын төлөөлөгчид оролцов.

1995.05.22-06.02. Монгол Улсын Эрчим хүч, геологи, уул уурхайн сайд Б.Жигжид Японы гадаад хэргийн яамны урилгаар Япон улсад айлчлав.

1995.05.30. Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл, гадаад харилцааны яамны урилгаар Японы Гадаад хэргийн яамны аюулгүй байдлын бодлогын хэлтсийн дарга С.Таруй манай оронд айлчлав. С.Таруй УИХ, УАБЗ, Батлан хамгаалах яам, Дорно дахины олон улс Судлалын хүрээлэнгийн төлөөлөгчидтэй уулзав.

1995.05.31. Францын “Хил хязгааргүй эм зүйчид” Олон нийтийн хүмүүнлэгийн байгууллагаас 454.000 долларын үнэ бүхий 32 тонн эм, эмнэлгийн барааг тусламжаар ирүүлжээ.

1995.06.06. Монгол Улсын Худалдаа үйлдвэрийн яам, Зах зээл Судлалын хүрээлэнгийн урилгаар НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн нийгэм эдийн засгийн комиссын доктор ноён Н.Жахардан ажлын айлчлал хийжээ.

1995.06.08. Монгол Японы улсын хамтарсан зөвлөлгөөн Улаанбаатар хотноо болж, гадаад худалдааг хөгжүүлэх нийгэмлэгийн Бээжин дэхь салбарын дарга Т.Морино нарын хүмүүс оролцов.

1995.05.25. АНУ-ын Конгрессын төлөөлөгчдийн танхимын Ази Номхон далайн салбар хорооны дарга Д.Бьюройтерийн санаачилсан монгол улсын анхны чөлөөт сонгуулийн 5 жилийн ойг тохиолдуулан Монголын ард түмэнд баяр хүргэсэн тогтоолыг Төлөөлөгчдийн танхим баталжээ. Уг тогтоолыг хамтран санаачлагчаар конгрессын гишүүн Х.Берман, Б.Гилман, Л.Хамилтон, Ж.Лийч, Д.Рохрабачер нар оржээ.

1995.06.15-16. Худалдаа үйлдвэрийн сайд Ц.Цогт тэргүүтэй төлөөлөгчид Брюсель хотноо монголд хөрөнгө оруулах худалдааг өргөжүүлэх асуудлаар болох дугуй ширээний уулзалтад оролцлоо.

1995.06.13. Монгол Улсын Засгийн газар ХБНГУ-ын Ханс Зайделийн сангийн хооронд эрх зүйн болон засаг захиргааны салбарт дэмжлэг туслалцаа үзүүлэх, эрх зүйн зөвлөлгөө өгөх хамтын ажиллагааны хэлэлцээрт Улаанбаатар хотноо Хууль зүйн сайд Н.Лувсанжав, тус санг төлөөлж доктор Р.Гепперт нар гарын үсэг зурав.

1995.06.15. Худалдаа үйлдвэрийн дэд сайдын урилгаар манай улсад айлчилж байгаа Германы холбооны эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга В.Хэртль Монгол Улсын Ерөнхийлөгчид бараалхав. В.Хэртлийг Монгол Улсын Ерөнхий сайд П.Жасрай хүлээн авч уулзав. Ноён Хэртль Германаас монголд үзүүлж буй зээл тусламжийн хэмжээг нэмэгдүүлэх боломжийг судлаж үзэж байгаагаа мэдэгдэв.

1995.06.20. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатад Мьянмарын Холбооны Улсаас манай улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Ү Сэт итгэмжлэх жуух бичгээ барилаа

1995.06.21-28. Японы үндэсний эдийн засгийн хүрээлэнгийн ерөнхийлөгч Е.Кано Азийн бүтээмжийн байгууллагын шугамаар эдийн засгийн судалгаа явуулах талаар зөвлөгөө өгч лекц уншив.

1995.06.21-29. Азийн бүтээмжийн байгууллагын гишүүн орнуудын ХАА-н боловсролын тогтолцооны талаар олон улсын судалгаа явуулах уулзалт ярилцлагаа боллоо. Үүнд Индонез, БНСУ, Монгол, Филиппин, Энэтхэг, Шриланк, Япон, Непал, Тайвань улсууд оролцов.

1995.06.20-25. УИХ-ын урилгаар ОХУ-ын Холбооны хурлын төрийн думын орлогч дарга А.Д.Венгеровский дагалдаж яваа хүмүүсийнхээ хамт манай оронд албан ёсны айлчлал хийлээ.

1995.06.20. АНУ-ын сансар судлалын “Аэроностик” үндэсний захиргаа Монгол Улсын Байгаль орчны Яамны хооронд хийсэн харилцан ойлголцох хэлэлцээрийн дагуу хиймэл дагуулаас мэдээлэл хүлээн авах системийг суурилуулж албан ёсоор хүлээлгэн өгөв.

1995.06.18-21. Английн Гадаад хэргийн яамны зүүн хойт Ази, Номхон далайн бүсийн асуудал хариуцсан орлогч сайд Кристофер Хан манай оронд айлчиллаа.

1995.06.22. Улаанбаатар хотын цахилгаан холбооны сүлжээний талаар хийх судалгааны ажлын хөтөлбөр, хэлэлцээний протоколд дэд бүтцийн хөгжлийн яамны холбооны газрын ерөнхий захирал Г.Баттөр “Монголын харилцаа холбоо” компанийн захирал О.Төмөр, Японы Шуудан холбооны яамны Олон улсын хамтын ажиллагааны хэсгийн түшмэл М.Мукода нар гарын үсэг зурав.

1995.06.26-07.01. Монгол Улсын Их хурлын дарга Н.Багабанди тэргүүтэй МУ-ын ИХ-ын төлөөлөгчид Украин Улс, Австрийн Холбооны Улсад албан ёсоор айлчиллаа.

1995.06.25-07.03. Монгол Улсын Их Хурлын дарга Н.Багабанди тэргүүтэй Монгол Улсын Их Хурлын төлөөлөгчид Украин Улсын Дээд зөвлөлийн дарга А.Мороз, Австри Улсын үндэсний зөвлөлийн дарга Х.Фишер нарын урилгаар Украин Улс, Австри Улсад албан ёсны айлчлал хийв.

1995.06.27. АНУ-ын олон улсын хөгжлийн агентлагаас хэрэгжүүлэх монголын эдийн засгийн хөгжлийг дэмжих төв нээгдлээ.

1995.06.27. Монгол Улс, Бүгд Найрамдах Максон улсын хооронд дипломат харилцаа тогтоолоо. Энэ нь манай дипломат харилцаатай 131 дэх улс болов. Македон улс 25 713 ам.км нутаг дэвсгэртэй 2.0 сая хүн амтай. Нийслэл Скоплед 300 мянга орчим хүнтэй ажгуу.

Манай улс хуучин Югославын бүрэлдэхүүнд байсан БНМакедон утсаас гадна, Слованитай 199 оны 2-р сарын 18-нд, Босна Герцоговинатай 1993 оны 2-р сарын 24-нд, Хорвоттай 1993 оны 3-р сарын 10-нд тус тус дипломат харилцаа тогтоосон юм.

1995.06.29. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатад Норвеги улсаас Монгол утсаад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Свере Верг Юхансен итгэмжлэх жуух бичгээ барилаа.

1995.07.01. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатад монгол дахь католик шашны төлөөлөгч, Ватиканаас манай улсад суугаа Нунцийн төлөөлөгч Уенесеслао Падилла бараалхаж, 1245 оны гуравдугаар сард IV Иннокентаас “Монголын эзэнт улс, ард түмэнд зориулсан захидал. Египетийн мамелукчуудын эсрэг тэмцэхэд папаас тусламж хүсч Персийн захирч байсан монгол хаан Газанаас VIII Бонифацид илгээсэн захидал зэрэг Витаканы нууц архивт хадгалагдаж буй монгол Улстай холбогдсон нэн чухал баримт бичгүүдийг гардууллаа.

1995.06.30. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатад Малайз Улсаас тус улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сиед Арис Фадзиллах итгэмжлэх жуух бичгээ барилаа.

1995.07.08-14. Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Бундестагийн дэд ерөнхийлөгч Бүрханд Хирш тэргүүнтэй төлөөлөгчид манай оронд айлчиллаа.

1995.07.14-19. Улсын Их Хурлын даргын урилгаар БНЭУ-ын Парламентын (Лок Сабха) доо танхимын дарга эрхэмсэг ноён Шивраж Патил тэргүүнтэй төлөөлөгчид манай оронд айлчиллаа.

1995.07.16-18. Японы Гадаад хэргийн яамны эдийн засгийн хамтын ажиллагааны газрын ерөнхий захирал ноён Хироши Хирабаяши манай оронд айлчлав.

1995.07.19. "Солонгос-Монголын харилцааны өнөө, ирээдүй" сэдэвт Монгол-БНСУ-ын эрдэмтдийн эрдэм шинжилгээний бага хурал болов. Хуралд доктор Ким Сун Хо, Ким Кван Рин, профессор Ким Ён Со, Чо Ок Ло, доктор Х.Дашдондов, Дэд доктор С.Дашцэвэл, М.Хурметхан нар илтгэл тавив.

1995.07.24-29. Монгол Улсын Ерөнхий сайд М.Жасрай тэргүүнтэй төлөөлөгчид Бүгд найрамдах Сингапур, Малайз улсад айлчиллаа.

1995.07.29. Европын холбооноос Монгол улсын Үндэсний стандарт хэмжил зүйн байгууллыг дэмжих төслийг хэрэгжүүлэхэд зориулж 977000 экю (нэг сая доллар)-ийн тусламж үзүүлэхээр шийдвэрлэжээ.

1995.07.31-08.12. Бурхан шашны тэргүүн XIV Далай лам: Данзанжамц тав дахь удаагаа манай оронд айлчилж “Дүйнхэрийн Ван”, “Лаирин дүйдэн” зэрэг ном айлдлаа.

1995.08.02-04. Азийн худалдааг дэмжих ес дэх удаагийн чуулган Улаанбаатарт болж, Азийн 14 орны төлөөлөгч оролцлоо.

1995.08.21-25. ШУБЯ, БОЯ, ШУА хамтран “Азийн экосистем түүнийг хамгаалах нь” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал боллоо.

1995.08.19. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатад Турк Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бальгин Унан итгэмжлэх жуух бичгээ барилаа.

1995.08.21-22. Монгол Туркийн Засгийн газар хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны комиссын анхдугаар хуралдасан Анкара хотноо болж, эрчим хүч, геологи, уул уурхайн сайд, энэ комиссын дарга Б.Жигжид тэргүүтэй төлөөлөгчид оролцлоо.

1995.09.04-15. Дэлхийн эмэгтэйчүүдийн IV бага хурал БНХАУ-ын Нийслэл Бээжин хотноо болж, Монгол улсаас хүн амын бодлого хөдөлмөрийн сайд Э.Гомбожав тэргүүтэй төлөөлөгчид оролцлоо.

1995.08.23. Улсын Их Хурлын дарга Н.Багабанди манай оронд ирээд байгаа АНУ-ын Конгрессийн Төсөв санхүүгийн хорооны дарга Харт фильд тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

1995.09.01-03. Батлан хамгаалах яамны сайд дэслэгч генерал Ш.Жадамба дайнд оролцогсдын монголын хорооны дарга, бэлтгэл хошууч генерал Д.Бямбацогт нар АНУ-ын Батлан хамгаалах яамны урилгаар Гавайн аргаад болсон дэлхийн хоёрдугаар дайн дууссаны 50 жилийн ойн ёслолын арга хэмжээнд оролцов.

1995.08.30-08.03. Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын номхон далайн баруун эргийн бүсийн захирал доктор Санг Тэй Хан манай оронд айлчиллаа.

1995.08.31. АНУ-ын Ерөнхийлөгч Б.Клинтон VIII сарын 22-ны өдөр төрийн нарийн бичгийн даргадаа 95-38 тоот захирамж явуулсан байна. Түүнд заасан ёсоор АНУ, Монгол улсад батлан хамгаалахын зориулалттай техник хэрэгсэл, сэлбэг нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх болсныг АНУ-ын Конгресс болон холбогдох бусад байгууллагад мэдээлэхийг үүрэг болгожээ.

1995.08.25-30. Чех улсын үйлдвэр худалдааны Яамны Европын бус орны газрын ерөнхий захирал Власпили Лоранз тэргүүтэй төлөөлөгчид айлчилж хоёр орны хооронд байгуулах худалдааны хэлэлцээрийн төслийг үзэглэжээ.

1995.09.07-08. АНУ-ын Ерөнхийлөгч Билл Клинтонь гэргий Хиллари Родхон Клинтон манай оронд анх удаагаа айлчиллаа.

1995.08.30. НҮБ-ын 50 жилийн ойд зориулсан Олон улсын парламентын холбооны (ОУПХ) Зөвлөлийн тусгай чуулган дээр Монгол улсын Их Хурлын дарга Н.Багабанди үг хэллээ.

1995.08.28. Монгол, БНСУ-ын эдийн засгийн хамтын ажиллагааны хоорондын гуравдугаар хамтарсан хуралдаан болж, хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн төлөв, Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх боломж, орчин нөхцлийн талаар хэлэлцэв.

1995.08.30-09.08. Засгийн газрын бус эмэгтэйчүүдийн байгууллагын чуулга уулзалтад БНХАУ-ын нийслэл Бээжин хотноо болж, Монгол улсаас монголын эмэгтэйчүүдийн холбоо, Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан, эмэгтэйчүүд-хөгжил хөдөлгөөний гишүүд, аймгийн

эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга нар зэрэг 1700 гаруй төлөөлөгч оролцлоо.

1995.09.11-13. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатын урилгаар Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхийлөгч Сулейман, Демирель манай оронд албан ёсоор айлчиллаа.

“Монгол улс, БНТУ хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны гэрээ”-нд хоёр ерөнхийлөгч гарын үсэг зурав.

1995.09.12-13. Дэлхийн банкны дэд ерөнхийлөгч Австрали Улсын иргэн Р.Чеедам монгол банкны урилгаар манай улсад айлчиллаа.

1995.09.18-09.30. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Унгар Улс, Бельгийн Вант Усад албан ёсны айлчлал хийлээ.

1995.09.19-22. Улаанбаатар хотноо НҮБ-ын Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссын удирдах бүлгийн долдугаар хуралдаан боллоо. Тус хуралдаанд дэлхийн 20 гаруй орон, олон улсын байгууллагын төлөөлөгчид оролцжээ.

1995.09.14-15. Шинжлэх Ухааны Академийн ДДОУС-ын хүрээлэн “Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцаанд хөрш орнууд” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулав. Тус хуралд Орос, Хятад, Японы эрдэмтэд оролцов.

1995.09.20. Японы цаг уурын нийгэмлэгийн гүйцэтгэх захирал Доктор М.Комабаяш нар Байгалийн гамшгийн тухай мэдээлэл цуглуулах, иргэдэд хүргэх талаар Байгаль орчны яамныхантай санал солилцов.

1995.09.27-30. Монгол Улсын Хилийн цэргийн удирдах газрын даргын урилгаар ОХУ-ын хилийн албаны захирал, хурандаа генерал А.И.Николаев манай оронд айлчиллаа.

1995.09.22-25. Бүгд Найрамдах Куба улсын Ази, Номхон далайн судлалын төвийн захирал Хосе Мануэль Галего манай улсад айлчилж ШУА-ийн Дорно дахин олон улс судлалын хүрээлэн, МУҮИС-ийн олон улсын харилцааны дээд сургуультай шууд харилцаа тогтоож, хамтын ажиллагааны төлөвлөгөөнд гарын үсэг зурав.

1995.09.30-10.29. Монгол улсын Шадар сайд Л.Энэбиш тэргүүтэй төлөөлөгчид АНУ-ын мэдээллийн агентлагийн шугамаар ажлын айлчлал хийлээ.

1995. 10.03-05. ОХУ-ын Эдийн засгийн гадаад харилцааны яамны орлогч сайд М.А.Сарафанов тэргүүтэй ОХУ-ын эдийн засгийн төв байгууллагын төлөөлөгчид манай оронд айлчиллаа.

1995.10.03-07. Батлан хамгаалах сайдын урилгаар ХБНГУ-ын Бундестагийн гишүүн, Үндэсний батлан хамгаалахын сайдлын дэргэдэх парламентын төрийн нарийн бичгийн дарга, Бернд Вильц манай оронд айлчиллаа.

1995.10.03-08. Монгол Улсын Их хурлын дэд дарга Ж.Гомбожав тэргүүтэй төлөөлөгчид БНУУ-ын Хурлын дэд дарга доктор Мацо Агнешийн урилгаар БНУУ-д албан ёсны айлчлал хийлээ.

1995.10.03-10.09. Английн Гааль татварын газрын “SOUTH and ON SEA” байгууллагын гаалийн ажилтан ноён Г.Браун, Австралийн сангийн яамны төлөөлөгч ноён С.Хобитер нар ирж Европын Холбооны ТАСИС хөтөлбөрийн шугамаар ажиллав.

1995.10.06-10. Нийслэлийн Засаг дарга Ц.Баасанжавын урилгаар Сөүл хотын дарга эрхэмсэг ноён Жо Сүн манай оронд айлчиллаа. “Улаанбаатар, Сөүл хотын хооронд ах дүү хотын харилцаа тогтоох тунхаглалд Ц.Баасанжав, Жо Сүн нар гарын үсэг зурлаа.

1995.10.04-13. АНУ-ын Вашингтон хотод болсон Дэлхийн банк, Олон улсын Валютын сангийн захирлуудын зөвлөлийн 1995 оны Ээлжит хуралдаанд Сангийн сайд Э.Бямбажав, монгол банкны ерөнхийлөгч Д.Моломжамц, мөн банкны тэргүүн дэд ерөнхийлөгч О.Чулуунбат, УИХ-ын төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогын байнгын хорооны дарга А.Базархүү нар оролцлоо.

1995.10.09-12. ОХУ-ын Засгийн газрын гишүүн, Гаалийн хорооны дарга А.С.Круглов тэргүүтэй төлөөлөгчид манайд оронд албан ёсны айлчлал хийлээ.

1995.10.08-10. Монгол-Японы эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд Японы Гадаад хэргийн яамны эдийн засгийн хамтын ажиллагааны газрын буцалтгүй тусламжийн хэлтсийн дарга Н.Окуда тэргүүтэй төлөөлөгчид манай оронд ажлын айлчлал хийлээ.

1995. 10.11. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатад Ангол улсаас манай улсад суух Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Луиша Докуи Паулу де Каштру итгэмжлэх жуух бичгээ барив.

1995.10.12. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатад Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри-Ланка улсаас манай улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Вильгельм Воутерз итгэмжлэх жуух бичгээ барив.

1995.10.16-18. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатын урилгаар Кувейт улсын эрхэм дээд Эмир Шейх Жабер Аль-Ахмед Аль Жабер Ас-Сабах манай оронд албан ёсоор айлчиллаа.

1995.10.12-17. Монгол Улсын Их Хурлын урилгаар БНХАУ-ын Шиньжаан Уйгарын өөртөө засах орны Ардын төлөөлөгчдийн их хурлын байнгын хорооны дарга Амудун Нияз тэргүүтэй төлөөлөгчид манай улсад албан ёсны айлчлал хийв.

1995.10.20-31. Италийн Ром хотноо болсон НҮБ-ын хүнс хөдөө аж ахуйн байгууллагын 28 дугаар бага хуралд Хүнс Хөдөө аж ахуйн сайд Д.Өөлд оролцов.

1995.10.14. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатад Кувейт Улсаас манай улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Абдул Мохсин Нассир Абдул Мохсин Аль-Жилаан итгэмжлэх жуух бичгээ барилаа.

1995.10.18. Монгол улсын Гадаад харилцааны сайд Ц.Гомбосүрэн Бүгд Найрамдах Куба улсын гадаад хэргийн сайд Роберто Робайна, Гонсалесын урилгаар тус улсад албан ёсны айлчлал хийв.

1995.10.18-10.30. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат гэргийн хамт НҮБ-ын 30 жилийн ойн ёслолын арга хэмжээнд оролцлоо. П.Очирбат энэ хугацаанд АНУ-ын ерөнхийлөгч Б.Клинтонтай уулзаж ярилцав.

1995.10.18. Гадаад харилцааны сайд Ц.Гомбосүрэн Колумб улсын Картахен хотноо болсон эвсэлд нэгдээгүй орнуудын төр засгийн газрын тэргүүн нарын XI бага хуралд оролцож үг хэлэв.

1995.10.31-11. МАХН-ын ерөнхий нарийн бичгийн дарга Б.Даш-Ёндон БНСУ-ын Ардчилсан либерал намын урилгаар тус улсад айлчиллаа.

1995.11.27-30. ОХУ-ын Засгийн газрын орлогч дарга эдийн засгийн гадаад харилцааны сайд О.Д.Давыдов тэргүүтэй төлөөлөгчид манай оронд ажлын айлчлал хийв.

1995.11.27-12.06. Монгол Улсын Гадаад харилцааны сайд Ц. Гомбосүрэн Япон Улсад албан ёсны айлчлал хийлээ.

1995.12.03-09. Худалдаа үйлдвэрийн сайд Ц. Цогт Австрийн Вена хотноо болох НҮБ-ын үйлдвэр хөгжлийн байгууллага (ЮНИДО-ын) ерөнхий бага хуралд оролцов. Бас Чехийн үйлдвэр худалдааны сайдын урилгаар тус улсад айлчиллаа.

1995.12.04-10. АНУ-ын нислэг сансрын уудмыг шинжлэх судлах үндэсний газрын төлөөлөгч, сансрын нисэгч Мэри Клив. Мөн газрын лабораторийн эрхлэгч, доктор Комптон Такер нар Байгаль орчны Яамны урилгаар Монголд айлчиллаа.

1995.12.13. “Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр” хэмээх төслийн бичигт Монгол Улсын Ерөнхий сайд П. Жасрай, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгч Ян Свитеринг нар гарын үсэг зурав.

Бэлтгэсэн Г.Ядамсүрэн.